

Үндсэн хуулийн үзэл санаа ба соёл иргэншлийн аюулгүй байдалд хамаарах зарим асуудал

Мягмарсүрэнгийн Амарбаяр

Хуульч, судлаач /LL.M/

Цахим хаяг: amarbayar04@gmail.com

Хураангуй: Үндсэн хуулиар баталсан, төрөөс шашны талаар баримтлах бодлогыг эрдэмтэн судлаачид зөрүүтэй тайлбарлаж, ойлгомжгүй байдал үүсгэсэн тул үүнийг тодорхой болгох шаардлага тулгарч байна. Сүүлийн үед Монгол Улсад шашны нөхцөл байдлын талаарх асуудал хурцаар хөндөгдөх болжээ. Монгол Улсын Үндсэн хуулиар “шашны” асуудлыг хэрхэн зохицуулсан, Үндсэн хуульд заасан “Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэсэн зарчим нь бүх шашныг илэрхийлж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, Үндсэн хуулиар төрөөс, шашны талаар баримтлах Үндсэн хуулийн үзэл санааг тодорхой болгох тал дээр судлаач байр сууриа илэрхийллээ. Шашны асуудал бол дан ганц шашин шүтэх хүний эрхтэй холбогддоггүй, улс орны нэгдмэл, аюулгүй байдлын асуудал давхар хөндөгдөж байдаг харилцаа юм. Үүнээс уламжлан “Иргэнишл” хэмээх олон талт өргөн ойлголтод шашны хамаарах хүрээг тогтоож Монголчуудын соёл иргэншлийн аюулгүй байдал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, үзэл баримтлалаар хэрхэн зохицуулсан талаар хөндөн гаргахыг оролдлоо.

Түлхүүр үгс: Үндсэн хууль, Үндсэн хуулийн үзэл баримтлал, бүрэн эрхт байдал, Төрөөс шашны талаар баримтлах бодлого, Үндэсний аюулгүй байдал, соёл иргэнишл, төрийн үүрэг.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлэгт Монгол улсын бүрэн эрхт байдлыг маш тодорхой хуульчилж өгсөн байна. Энэхүү Бүрэн эрхт байдалд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, төрийн байгууламжийн хувьд ямар байх, улсын хил болон түүх соёлыг хамгаалалтад авах тухай, Монгол улсын төрөөс шашны талаар баримтлах байр суурь, бодлого, төрийн үүрэг, төрийн бэлгэ тэмдэг зэргийг хуульчлан тогтоожээ¹.

Дээрхээс харахад Улсын бүрэн эрхт байдалд хамаарах нэгэн чухал зүйл бол “Шашин”-ы асуудал буюу Монгол Улсын төрөөс шашны талаар баримтлах үзэл баримтлал, бодлого юм. Үүний тухай илүү тодруулан, нухацтай ярих цаг болсон тул шашны талаарх төрийн бодлого, Үндсэн хуулийн үзэл баримтлалын зөрүүтэй ойлголтыг тодорхой болгох асуудлыг дор тусгайлан өгүүлнэ.

“Шашин”-ы асуудлыг зарим судлаач, эрдэмтэд Хүний шашин шүтэх эрх, шашны эрх чөлөө гэсэн нэрийн дор орхигдуулж, нийтээрээ түүнийг хүлээн зөвшөөрч буй явдал газар авч байна. “Шашин”-ы асуудал бол Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдох асуудал мөн боловч нөгөө талаараа Улсын бүрэн эрхт байдал, соёл иргэншлийн аюулгүй байдалтай шууд хамааралтай эмзэг асуудал билээ.

Монгол Улс өөрийн нутаг дэвсгэр дээр өөрийн асуудлаа Үндсэн хуульд

тунхагласан “хууль дээдлэх ёс”² зарчимд үндэслэн бие даан шийдвэрлэх бүрэн эрх нь Монгол улсын тусгаар тогтнолыг илэрхийлэх нэг үндсэн шинж чанар болж өгдөг билээ. Энэхүү бүрэн эрхийн хүрээнд Монголын төрөөс шашны талаарх бодлогыг хэрэгжүүлэн ажиллахдаа Үндсэн хуулийн үзэл санааг зөрүүтэйгээр тайлбарлаж ирсэн, зарим талаар төрөөс шашны талаар баримтлах бодлого, зарчим тодорхой бус байгаагын улмаас шашны нөхцөл байдал хүндэрсэн нөхцөл байдалтай байна. Үндсэн хуулиар баталсан төрөөс шашны талаар баримтлах үзэл баримтлалыг тухайн үеийн хууль тогтоогчид, АИХ-ын депутатын илэрхийлсэн үзэл санаа, агуулгаар нь нийгэмд ойлголт өгөөгүй, улмаар төрөөс шашны талаарх бодлого ойлгомжгүй нөхцөл байдалтай, холбогдох эрх зүйн орчны зохицуулалт сул зэрэг нь гаднаас олон шашин орж ирэх нөхцөлийг бүрдүүлж Монголын соёл иргэншлийн аюулгүй байдалд нөлөөлж байна.

1. Үндсэн хуулиар баталсан, төрөөс шашны талаар баримтлах бодлогын зөрүүтэй ойлголтыг тодорхой болгох асуудалд

Монгол Улсын ард түмэн бид улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүмүүнлэг ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг зорилго болгосон билээ.

1 Монгол Улсын Үндсэн хууль. Нэгдүгээр бүлэг, “Монгол Улсын Бүрэн эрхт байдал” 1 – 13 дугаар зүйл

2 Монгол Улсын Үндсэн хууль, /1992он/ Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд³ Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ, төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг тусдаа хуулиар зохицуулахаар тусгаж өгсөн. Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл нь Төрийн бүрэн эрхт байдалд хамаарах бөгөөд төрөөс шашны талаар баримтлах бодлого, үзэл баримтлалыг тусгаж өгсөн ба энэхүү заалт нь шашин шүтэх хувь хүний эрхийн зохицуулалтыг шууд утгаар агуулаагүй, *төрийн бүрэн эрхт байдалд хамаарах, төрөөс шашны талаар баримтлах бодлогыг тодорхойлон өгсөн зүйл заалт юм.*

Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 9 дүгээр зүйлээр Улсын бүрэн эрхт байдалд хамаарах төрөөс шашны талаар баримтлах бодлогыг тодорхой тусгаж зохицуулсан бол Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд Хүний эрх, эрх чөлөө болох шашин шүтэх хүний эрх, эрх чөлөөг тусгайлан хуульчилж өгсөн байна. Үндсэн хуулийн тухайн зүйлүүд нь хэдий харилцан хамааралтай боловч утга, агуулга болон зохицуулалтын хувьд тэс өөр агуулга бүхий юм. Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл нь Улсын Бүрэн эрхт байдалд хамаарах хүрээгээрээ төрөөс шашны харилцааг бие даан зохицуулах, шашны асуудлаар төрөөс баримтлах бодлогыг хуулийн хүрээнд тодорхойлох, үндэсний аюулгүй байдлын хүрээнд авч үзэхээр хуульчилсан. Гэтэл нийгэмд Үндсэн хуулийн төрийн бүрэн эрхт байдалд

хамаарах шашны асуудлыг Шашин шүтэх хүний эрхтэй хольж хутган, зөвхөн хүний эрх гэж өрөөсгөл тайлбарлан санаатай, санамсаргүйгээр ярилцах болсон байна. Шашин нь Үндэсний аюулгүй байдалтай шууд хамаарах асуудал болохыг гадаад улс орнуудын шашны зөрчилдөөнүүдээс харж болно. Улс орнууд шашныг нийгмийн үнэт зүйл болохыг харгалзан соёл иргэншлийн аюулгүй байдлын хүрээнд авч үзэх болжээ. Харин манай улсын хувьд шашныг нийгмийн үнэт зүйл, уламжлал, соёл иргэншлээс салангид авч үзэн нийгэмд үзүүлэх нөлөөг үл тоомсорлосоор ирсэн байна.

Хэдийгээр Үндсэн хууль нь нийгмийн хөгжил дэвшлийг даган агуулгын хувьд өөрчлөгдөх, тайлбарлагдах боломжтой боловч Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлэгт заасан *“Бүрэн эрхт байдал”* бол өөрчлөгдөх шинж чанаргүй, судлаач болон эрдэмтдийн тайлбараар өөр өөрөөр тайлбарлагдах шинж агуулаагүй, агуулах боломж ч үгүй Үндсэн хуулийг батлахад *ард түмэн бүрэн эрхт байдлаа ийн хэмээн тодорхойлж томъёолсон, нэг мөр ойлголттойгоор хуульчилж өгсөн үнэт зүйл, үзэл баримтлал юм.*

Тиймийн тул улсын бүрэн эрхт байдалд хамаарах “Шашны бодлого”-ын тухай Үндсэн хуульд хэрхэн туссан болон бүрэн эрхт тусгаар улсын хувьд соёл иргэншлийн цөм болсон шашны талаар баримтлах бодлогыг хэрхэн хуульчилсан талаар зайлшгүй ярих шаардлагатай. Үндсэн хуулийг

3 Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Нэгдүгээр бүлэг, Монгол Улсын бүрэн эрхт байдал, Есдүгээр зүйл.

тайлбарлах арга зүйгээр⁴, Үндсэн хуулийн төслийг батлахад ямар үзэл баримтлалаар, ямар агуулгаар тухайн нэр томъёо хэрэглэгдсэн, ямар агуулгаар хэлэлцэн баталсныг хурлын тэмдэглэл, архивийн баримт зэргээс судлан гаргаж судлаачид, эрдэмтэд, төрийн эрх барьж буй нөхөд, олон нийтэд тайлбарлан таниулах нь зүйтэй.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийг Монгол Улсын Үндсэн хуулиар хүний шашин шүтэх эрхийг хангахын тулд **Төрөөс бүх шашныг хүлээн зөвшөөрнө** гэсэн агуулгаар явцуу хүрээнд тайлбарлаж, нийгэмд тэр дагуу ойлгуулж ирсэн.

Өнгөрсөн 30 жил, нийгмээрээ тухайн асуудлыг тайлбарлах өнцөг, ойлголтын талаар зарчмын зөрүүтэй төдийгүй Үндсэн хуулийн үзэл баримтлалаас тэс өөр утга агуулгаар тайлбарлаж ирснээр төрөөс шашны талаар баримтлах бодлогийг ойлгомжгүй байдалд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн хууль тогтоогчдын анхны үзэл санаа, үзэл баримтлалыг үгүйсгэх хэмжээнд хүрсэн гэж үзэж болохоор байна. Тодруулбал, Монгол Улс бүх шашныг хүлээн зөвшөөрдөг

гэж Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд заасан үзэл баримтлалаас зөрүүтэй тайлбарлагдах болсны улмаас Монгол Улсын соёл иргэншилд ноцтойгоор нөлөөлсөн, төрөөс шашны талаар авч хэрэгжүүлэх бодлогод тодорхойгүй нөхцөл байдал үүссэн, төрийн эрх бүхий байгууллага шашны асуудлыг шийдвэрлэх чадваргүй нөхцөл байдалтай тулгарсан, Монгол улсын шүүхээр түүнтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэхэд үл ойлголцох асуудал тулгарсан, нийгмийн сэтгэхүйд төрөөс шашны талаар авч хэрэгжүүлэх бодлого, шашин шүтэх хүний эрх, эрх чөлөөний талаар буруу ойлголт бий болсон зэрэг олон асуудал тулгараад байна. Эдгээр бүгдийг мэргэжлийн талаас судлах, олон нийтэд зөв зүйтэйгээр тайлбарлан таниулах, дүн шинжилгээ хийх, Үндсэн хуулийн үзэл санаа, төрийн баримтлах бодлого зэргийг нийгэмд үнэн зөвөөр ойлголт өгөх нь зүйтэй байна.

Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг Үндсэн хууль хэлэлцсэн хууль тогтоогчид буюу ард түмний төлөөлөл, депутатууд хэрхэн хэлэлцэж, баталсан талаар зайлшгүй судлаж тодорхой болгох ёстой.

1990 онд нийгмийн шинэ өөрчлөлт,

4 Манай судлаач, эрдэмтэд Үндсэн хуулийн үзэл санаа, шашны талаар төрөөс баримтлах бодлогыг хүний шашин шүтэх эрх чөлөө гэх хэт явцуу хүрээнд тайлбарлаж иржээ. Гэтэл энэ тайлбар нь өнөөгийн нийгэмд гарч буй дээрхи асуудлыг шийдэхэд дөхөм болохуйц тайлбар биш учир Үндсэн хуулийн шашны талаархи үзэл баримтлалыг өөр арга замаар тайлбарлах шаардлага бий болоод байна. Үндсэн хуулийг тайлбарлах 1) **Textualism** 2) **originalism** 3) **judicial precedent** 4) **pragmatism** 5) **moral reasoning** 6) **national identity or national ethos** 7) **structuralism** 8) **historical practices** аргууд байдаг. Судлаач миний зүгээс энэхүү аргуудаас "**Ориганизм**" буюу Үндсэн хуулийг тогтоогчдын үзэл санааны үүднээс тайлбарлах нь зүй ёсны бөгөөд өнөөгийн асуудлыг шийдэх гол арга зам байх боломжтой гэж үзэж байна. Түүнчлэн, үндэсний ухамсар буюу **national identity**-ийн хүрээнд, **historical practices** түүхчилсэн, **Textualism** буюу шууд утгаар зэрэг аргуудаар ч тайлбарлах боломжтой. Монгол Улсын хувьд Үндсэн хуулиа батлаад 30 жил өнгөрч буй нь энэ аргуудаар тайлбарлах өргөн боломжийг олгож байна. Цаашид ч Үндсэн хуулийн тухайн зүйл заалтыг тайлбарлахад дээрх аргуудаас алийг нь авч хэрэглэх талаар анхаарах ёстой бөгөөд Үндсэн хуулийн **Нэгдүгээр бүлгийг** "Бүрэн эрхт байдал" -ыг тайлбарлахдаа хууль тогтоогчид хэрхэн ямар агуулгаар хэлэлцэж, баталж байсныг тайлбарлах нь илүү зүй зохистой юм.

шинэчлэлттэй уялдуулан Үндсэн хуулийг батлах явцад төрөөс шашны талаар баримтлах бодлогыг маш нухацтай, тал бүрээс нь нягтлан хэлэлцэж баталсан юм. Тухайлбал, Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийг Төр, шашны харилцаа, тэр тусмаа уламжлалт бурхан шашны зохион байгуулалт нь өмнөх нийгмийн үе шиг төрийн үйл хэрэгт оролцохгүй байх тухай хуульчилж өгсөн байна.

Ардын Их Хурлын депутатууд 9 дүгээр зүйлийг нягтлан хэлэлцэж улмаар, 38 дугаар тойргын депутат Д.Чойжамц⁵ Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хэлэлцүүлгийн явцад төслийн хэлэлцүүлэгт оруулсан саналын үндсэн зарчмыг “... Монголын уламжлалт төр, шашин хоёрын харьцааг тодорхойлсон ...Үүнийг ерөнхий зүйл болгож ...**төрийн шашнаа хүндэтгэж үзнэ гэж, шашин төрөө дээдлэнэ гэсэн ...ерөнхий заалтад ийм үг байвал яасан юм бэ.**”⁶ гэсэн саналыг гаргаж, энэхүү санал дэмжигдэж эцсийн байдлаар хэлэлцэгдэн батлагджээ⁷.

Энэхүү саналуудаас үзвэл төр болон шашны үйл ажиллагаа тусгаар байх үндсэн агуулгаар, зөвхөн уламжлалт бурханы шашинг төр хүлээн зөвшөөрсөн агуулгаар хэлэлцэгдэж *Төр нь шашнаа хүндэтгэнэ, шашин төрөө дээдлэнэ* хэмээн батлагджээ. Энэ нь Нэгдүгээрт,

уламжлалт бурханы шашин нь төр, улсын аюулгүй байдал, түүнчлэн Монгол Улсын бүрэн эрхт байдалд хамаарах асуудал болохыг харгалзаж үзэх, Хоёрдугаарт, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд аливаа шашны үйл ажиллагаанаас ангид байх, уламжлалт бурханы шашны удирдлагыг өмнөх нийгмийн үе шиг төрийн үйл хэрэгт оролцохгүй, тодорхой хэмжээнд тусгаар байлгах, Гуравдугаарт, төр бүх шашныг хүлээн зөвшөөрнө гэсэн агуулгаар тусгагдаагүй, Дөрөвдүгээрт, шашны асуудлыг илүү нарийвчилсан хуулиар зохицуулах, Тавдугаарт, бусад итгэл үнэмшил, шашин нь уламжлалт бурханы шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзэх тухай агуулгатай байна.

Ийнхүү Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд заасан Монгол Улсад төр нь шашнаа дээдлэнэ гэдэг заалтад дурдагдсан **төр нь, төрийн** гэсэн хуулийн нэр томъёогоор анхлан тусаж хэлэлцүүлгийн явцад **төр нь** хэмээн өөрчлөгдсөн, **шашныгаа** буюу уламжлалт бурханы шашныгаа гэдэг нь **шашнаа** хэмээн хамаатуулан, үг зүйн хувьд өөрчлөгдөн хуульчлагдсан байна. Монгол Улсын төр нь тусгаар улсын хувьд уламжлалт *Бурханы шашнаа* хүндэтгэн үзэх бөгөөд *Бурханы шашин* нь **төрөө дээдлэн** барих үзэл баримтлалыг маш тодорхой Үндсэн хуульд суулгаж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, Бурханы шашин бол

5 Гандантэгчинлэн хийдийн хамба лам

6 БНМАУ-ын АИХ-ын 2 дахь удаагийн сонгуулийн II хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл. Тал 86. 1991.11.25. / соронзон хальсны бичлэг кассет Y-54/

7 Монголын уламжлалт шашин, төр хоёрын харилцааг энэхүү зүйлээр зохицуулж байна. Төр, шашин хоёрын харилцааг тодорхойлоход Монголын түүх, уламжлалыг бүрдүүлэх чухал хүчин зүйл болсон бурханы шашны үүрэг ролийг умартаж болохгүй. Гиймээс төрийн шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэнэ гэсэн ерөнхий заалт байсан нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн байна. Улмаар, уг санал нь их хурлын депутатуудын дунд дэмжигдэж найруулгын хувьд үл ялиг өөрчлөгдсөнөөр өнөөгийн 9-р зүйл хэлэлцэн батлагдажээ.

Монгол Улсын төрийн хүндэтгэн үзэх шашин мөн⁸ гэж Үндсэн хуулиар хуульчилж өгсөн байна.

Үндсэн хуулийн үзэл санаагаар Уламжлалт бурхан шашинд зонхилох байр суурийг хүндэтгэн үзэж Төр нь уламжлалт бурхан ШАШНАА хүндэтгэж, бурханы шашин нь төрөө дээдэлнэ гэсэн агуулга нь Уламжлалт бурханы шашинд “тусгай статус” олгосон гэж үзэхээр байна. Уламжлалт бурханы шашинд тусгай статус олгож хүндэтгэн үзэх нь бусад шашинг үгүйсгэж байгаа явдал биш бөгөөд гагцхүү “төр-шашны харилцаа”-нд Бурханы шашин бол Монгол Улсын Тусгаар тогтнол, аюулгүй байдал, Улсын бүрэн эрхт байдалтай шууд хамаарах бөгөөд гүнзгий утгаараа үндэсний ухамсар, соёл иргэншлийг авч үлдэх нарийн бодлого, агуулгатайгаар тусгаж өгсөн байна.

Монгол Улс нь бурханы шашныг хүндэтгэн үзсэнээрээ бусад итгэл үнэмшилтэй хүмүүсийн шашин шүтэх эрхийг хөндөж байгаа хэрэг биш юм. Харин шашныг гаднаас зохион байгуулалттайгаар оруулж ирэх, тухайн шашин Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд саад учруулах бол төрөөс тухайн шашны үйл ажиллагааг зохицуулах бүрэн эрхийг олгож буй явдал юм.

Уламжлалт шашныг хүндэтгэн үзэхдээ бусад шашин шүтэгчдэд саад болохгүй бөгөөд иргэдийн шашин шүтэх эрхийг ямар тохиолдолд зөрчсөн гэж үзэхийг зарим судлаач “...бусад шашны цөөнхөд итгэл үнэмшилтэй байх, сүсэглэж биширэх, түүнийгээ илэрхийлэх хуулийн баталгаа олгоогүй нөхцөлд шашин шүтэх эрх чөлөөг зөрчих нөхцөл үүсдэг.”⁹ гэж тайлбарлажээ. Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар бусад шашин шүтэгчид сүм, хийдээ байгуулах, шашин шүтэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгосон байна.

Гагцхүү Үндсэн хуулиар баталсан, төрөөс шашны талаар баримтлах бодлогыг бүх шашин тэгш эрхтэй, шашин зөвхөн хүний эрх учраас төр оролцох эрхгүй гэж зөрүүтэй тайлбарладаг асуудлыг тодорхой байдлаар цаашид тайлбарлах нь зүйтэй байна.

Дэлхийн олон улс оронд үндэсний уламжлалт шашнаа хуулиар баталгаажуулан хүндэтгэн үздэг байна. Тухайлбал, ОХУ-д “Оросын түүх, оюун санаа болон соёлын хөгжилд гүйцэтгэсэн Үнэн алдартны шашны онцгой үүргийг хүлээн зөвшөөрөх ...эрхэмлэх нь зүйтэй”¹⁰ гэж хуульчилсан байдаг. Польш улсын

8 Үндсэн хуулийн цэцийн 1994.01.12 өдрийн хуралдааны ТСХХтХуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн маргааныг хянан хэлэлцсэн хурлын протокол. Тал 220.

УИХ итгэмжлэгдсэн төлөөлөгч УИХ-ын гишүүн Ч.Ган-Өлзийгийн тайлбар “...УИХ-ын энэ зүйлийг эцэслэн баталсан. Хуралдаанд энэ заалтыг нэг шашин гэж ойлгож баталсан. Тийм үзэл баримтлалаар баталсан. Тухайлбал Бурханы шашныг хамааруулан ойлгож байна гэж баталсан. Тийм үзэл баримтлалын үүднээс баталсан...” гэж Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д заасан “Төр нь шашнаа хүндэтгэнэ” гэсэн зүйл заалтыг цэцэд тайлбарласан.

9 Д.Гангабаатар “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө ба Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн проктик” Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2017 он. Дугаар 02, цуврал 62, тал 101.

10 Law on freedom of conscience and religious associations “The Federal Assembly of the Russian Federation, recognizing a special role of the Orthodox Church in the history of Russia, the formation and development of its spirituality and culture”

Үндсэн хуульд “...Бүгд найрамдах Польш улс болон Католик сүм хийдийн хоорондын харилцааг Ватикантай байгуулсан олон улсын хэлэлцээр, хуулиар тодорхойлно.”¹¹ гэж заажээ. Харин Итали улсын Үндсэн хуулинд “...Католик шашнаас бусад шашин Итали улсын хуультай зөрчилдөөгүй тохиолдолд өөрийн дүрэмд нийцсэн бие даасан байгууллагатай байх эрхтэй”¹² гэж зааж өгсөн бол ХБНГУ-ын Үндсэн хуулийн удиртгал хэсэгт “...Бурхан болон Хүний өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан ...Германы ард түмэн бид өөрсдийн үндсэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийг батлав.”¹³ мөн Германы Үндсэн хуулийн “Шашин ба Шашны нийгэмлэг”-ийн тухай хуулиар илүү нарийвчлан зохицуулалт хийж өгсөн байна.

Эдгээр улсууд олон зуун жилийн түүхтэй үндэсний шашнаа, нийгмийн үнэт зүйл, ард түмний соёл иргэншил, хүсэл зоригын илэрхийлэл мөн гэж үзэн Үндсэн хуулиараа хуульчлан баталгаажуулж өгчээ. Улс үндэстэн бүр үндэсний шашин соёлыг авч үлдэхэд анхааран төрийн бодлогоор дэмжиж

өгдөгийн гол санаа, үзэл баримтлал нь тухайн шашин соёл иргэншлийг нь хамгаалах чухал ач холбогдолтой оршино.

Манай улсад Үндсэн хуулиар баталгаажсан бүрэн эрхт байдлаа сахин хамгаалахад Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд соёл иргэншлийн аюулгүй байдлыг тодорхойлон, уламжлалт Бурханы шашин, соёлыг хамгаалж¹⁴ уламжлан авч үлдэх агуулгатай зохицуулсан¹⁵ боловч тус зохицуулалт нь ойлгомжгүй, тодорхойгүй байна. Шашны асуудал нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай холбогддог учраас Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх аливаа асуудалд төрийн зүгээс тодорхой бодлого баримтлан ажиллах, үндсэн хуульд ёсыг сахин хамгаалах үүргийн дагуу Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг боловсруулан баталжээ.

Тус хуулиар сүм хийдийн тоог төрөөс хянах, гаднаас шашныг зохион байгуулалттай¹⁶ дэлгэрүүлэхийг хориглохоор хуульчилсан¹⁷ байна. “Зохион байгуулалттай” гэдэг нь гадны улс орноос тодорхой зорилго

11 БНТУ-ын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг орч. Б.Лхагважав, Ж.Алтангэрэл

12 БНИУ-ын Үндсэн хуулийн 8 дугаар зүйл орч. Ж.Амарсанаа

13 Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль “Удиртгал хэсэгт” орч. П.Амаржаргал Х.Ариунсүрэн нар УБ. 2020. Тал 15.

14 Аливаа шашны байгууллага Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэхдээ үндэсний аюулгүй байдалд дурдсан соёл иргэншлийн аюулгүй байдалд халдахгүй байх үүрэгтэй бөгөөд монголчуудын уламжлалт соёл, шашныг хүндэтгэн үзэх ёстой. Тухайн шашны үзэл номлол нь монголын ард түмний эв нэгдэл, аюулгүй байдалд хор хохирол учруулах ёсгүй бөгөөд шашны итгэл үнэмшил, үзэл бодлоороо ялгаварлан гадуурхахгүй байх, үзэл номлолоо хүчээр тулган, иргэдийн хооронд үл ойлголцол төрүүлэх, өдөөхийг хатуу хориглоно.

15 Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” 3.1.4.Соёл иргэншлийн аюулгүй байдал, 3.1.4.1.Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч... хамгаалан хөгжүүлнэ.

16 Үндсэн хуулийн цэцийн 1994.01.12 өдрийн хуралдааны ТСХХТХуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн маргааныг хянан хэлэлцсэн хурлын протокол. Тал 192. УИХ итгэмжлэгдсэн төлөөлөгч УИХ-ын гишүүн Ч.Ган-Өлзий тайлбарлахдаа “...Зохион байгуулалт гэхээр олон хүнийг хамарсан, цаанаасаа санхүүждэг, тодорхой зорилготой ийм 3 зүйлийг хэлнэ” гэжээ.

17 ТСХХТХуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг

чиглэлтэй, түүнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөсөн, шаардлагатай санхүүжилт, гүйцэтгэх бүтэцтэй цогц үйл ажиллагааг ойлгоно. Гэвч энэхүү хуулийн заалтыг хэн, хэрхэн, яаж хэрэгжүүлэх, эрх зүйн механизм сул, төрийн хяналт тавих эрх бүхий байгууллага огт хэрэгжүүлээгүйн улмаас өнөөдрийн байдлаар шашны 50 гаран урсгалын 848 шашны байгууллага, шашны чиглэлээр 40 гаран олон улсын ТББ, өөр зорилго, үйл ажиллагааны хэлбэрээр халхавчлан цөөнгүй шашны байгууллагууд үйл ажиллагаа эрхэлж байгаа зэрэг нөхцөл байдалтай байна. .

Тэр ч утгаараа төр болон сүм хийдийн харилцаа, шашны харилцаа, шашин хоорондын харилцаа, шашин шүтэх хувь хүний эрх чөлөөний ойлголт ч нийтийн эрх ашиг, үндэсний аюулгүй байдалтай холбогдохыг тухайн үеийн хууль тогтоогчид урьдчилан харж, шашныг Улсын бүрэн эрхт байдалтай шууд холбон Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлэгт оруулж өгчээ. Үүнийг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг анхлан батлах үйл явцад илүү нарийвчлан хэлэлцэж байсан төслийн концепцээс харж болно. *“Иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай БНМАУ-ын хуулийн”*¹⁸ төслийн талаарх товч илтгэлд *“...Энд онцлон тэмдэглэвээс зохих нэгэн зүйл бол, манай оронд буддын, лалын, христосын зэрэг олон шашин дэлгэрч, тэдгээрийг даган бусад орны улс төрийн бодлого орж ирэх боломжийг ч үгүйсгэхийн эрхгүй байгаа нөхцөлд одооноос нийгмийг*

*шашны хагарал, мөргөлдөөний талбар болгон хувиргахаас сэргэмжлэх явдал нэн чухал байна.”*¹⁹ гэснээс манай улсад олон төрлийн шашин орших нь эрсдэлтэй гэж үзэж, тодорхой хяналт зайлшгүй авах ёстойг дурдаж байжээ.

2. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дахь соёл иргэншлийн аюулгүй байдлын зохицуулалт, агуулга

Хүн төрөлхтөн үүссэн цагаас өөр өөрсдийн иргэншлийг бий болгон нийгмийн зүй тогтлоор хувьсан өөрчлөгдөн хөгжиж ирсэн. Улс үндэстэн бүр үндэстний соёлыг хадгалж бусдаас ялгарах онцлог шинж чанар, нийгмийн сэтгэл зүй, зан үйл, уламжлал, ёс заншил оюуны үнэт зүйлийг тээдэг.

Соёл иргэншил хэмээх ойлголтыг Өрнийн болон Дорнын, суурьшмал болон нүүдлийн гэж ангилан соёл иргэншлийн ойлголтыг явцуу утгаар тайлбарлахаас илүү өргөн хүрээнд, түүний мөн чанар юунд агуулагдаж байгааг онолын хувьд авч үзэх, түүнд хамаарах асуудлыг тодорхой нарийвчлан судлан гаргах шаардлагатай байна.

Соёл иргэншил нь тус бүс нутагт улс орон, ард түмний соёл болон итгэл үнэмшил, үнэт зүйлсийн ижилслийг бий болгож, тэрхүү үнэт зүйлсийн мөн чанар нь Шашин болж өгдөг бөгөөд шашин нь аугаа иргэншлүүдийг үүсгэх тулгуур үндэс, төв, гол шинж чанар болж үндэстний соёлын бүхэллэг

¹⁸ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн анхны төслийн нэр

¹⁹ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хувийн хэрэг, УИХ-ын тамгын газар, тал 29.

байдлыг илтгэдэг ажээ.

Эдүгээ дэлхийн улс орнууд даяаршиж буй үед дэлхийн соёлтой хөл нийлүүлэн алхах, хөгжил дэвшилд тэмүүлэн хүчин чармайлт гаргах нь зүй ёсны хэрэг боловч бусдаас ялгарах уламжлалт зан үйл, сэтгэлгээ, тэр тусмаа иргэншлийг, итгэл үнэмшил, уламжлалт шашин шүтлэгийг авч үлдэх юу юунаас илүү чухал зүйл юм.

Аливаа иргэншлүүдийг ялгах гол шинж чанар, хамгийн гол хүчин зүйл “Шашин” болохыг иргэншлийн талаар судалгаа хийж томоохон бүтээл туурвисан эрдэмтдийн онолуудаас харж болно. Самуэл П.Хатингтон *“Иргэншлийг тодорхойлох объектив элементүүд дотроос хамгийн чухал нь Шашин, ...Хүн төрөлхтөний түүхэн дэх гол иргэншлүүдийг дэлхийн том шашнуудтай төрөлсүүлэх нь маш элбэг”*²⁰, мөн монголчуудыг буддист иргэншилтэй²¹ хэмээн дурдсан байна. Иргэншил бол тэд бид биш, бид тэд биш гэдгийг тод томруунаар ялгах, түүнийгээ ойлгож ухамсарлах,

үндэстэн бусдаас ялгарах гол онцлог, өөрсдийгөө илэрхийлсэн үнэт зүйл болохыг илтгэж байна.

О.Шпенглэр соёл иргэншлийг “соёлын эцсийн цэг”²² хэмээн иргэншлийг тухайн соёлын талаас тайлбарлах онолыг дэвшүүлсэн бол А.Тойнби иргэншлүүдийн доройтол буурлын шалтгааныг эдийн засаг, хүрээлэн буй орчны асуудлаас илүүтэйгүүр “ёс суртахуун, шашны доройтол”²³ хэмээн тодорхойлжээ.

Иргэншлийн онолыг Амарти Сен /Amartya Sen/²⁴, Паул Берман /Paul Berman/²⁵ судлаач, эрдэмтэд олон улсын харилцаа талаас барууны иргэншлийг барууны бус иргэншлүүдийн ялгаа онцлогыг судлан тайлбарласан байдаг байна. Эдгээр тайлбарууд нь шашны үзэл номлол нь тухайн үндэстний иргэншлийн цөм болж өгдөгийг хүлээн зөвшөөрдөг ажээ.

Харин манай улсад шашны нөхцөл байдал нь соёл иргэншилд хэрхэн нөлөөлж, ямар байдалтай байгаа талаар

20 Самуэл П.Хатингтон “Иргэншил хоорондын мөргөлдөөн ба Шинэчлэгдсэн дэлхийн дэг журам” УБ., 2018. Тал 41. Орч. А.Энхбаатар

21 Мөн тэнд. Тал 50. “...Буддизмыг соёлынхоо чухал хэсэг болгож чадсан. ...Монголын ...хүн ам нь махаяны урсгалайн шашныг шүтэж ирсэн түүхтэй. Иймд эдгээр улс Буддист иргэншлийн 2 дахь орон зайг бүрдүүлдэг...”

22 “Civilization is the ultimate destiny of Culture” дэлгэрэнгүйг Assem Koishybayeva “Essay The Decline of the West by Oswald Spengler” p.,2 https://www.academia.edu/10710737/Essay_The_Decline_of_the_West_By_Oswald_Spengler

23 Mubarak Ali “Toynbee on civilisation” <https://www.thenews.com.pk/print/325178-toynbee-on-civilisation>
Arnold J.Toynbee “A Study of history”, 1934-1961 Артур Тойнби “Түүхийн судалгаа”, 12 боть бүтээл, Энэхүү бүтээлээр А.Тойнби дэлхий дахины түүхэнд оршин тогтносон 21 соёл иргэншлийн өсөлт, бууралт, хөгжлийг судалсан байдаг.

24 Amartya Sen “Democracy as a Universal value” ., Journal of democracy, №3-17, 1999 хэмээх нийтлэлдээ Хантингтоны онолын тухайд “Соён гэгээрэл болон аж ахуйн хувьсгалаас эхлэлтэй барууны орнуудын зөвшилцлийн үр дүнд сүүлийн 100 жилд Ардчилал нь давамгайлах улс төрийн систем болж чадсан. Энэхүү барууны орнуудын олон зуун жилийн хөдөлмөрийн үр дүнд үүссэн ардчилалыг барууны бус орнуудын уламжлалуудтай эсрэгцүүлэх нь маш том алдаа болно” гэж тэмдэглэсэн байна.
https://www.unicef.org/socialpolicy/files/Democracy_as_a_Universal_Value.pdf p.,9

25 Paul Berman “Terror and liberalism”., 2003, Norton&company хэмээх бүтээлдээ “зөрчилдөөн нь иргэншил хоорондын шашны ялгаанаас бий болдог, бүлгүүд хоорондын философийн хандлагаас бий болдог” гэж дурдсан байна. <https://www.commentarymagazine.com/articles/david-warren/terror-and-liberalism-by-paul-berman-the-crisis-of-islam-by-bernard-lewis/>

цухас авч үзье. Сүүлийн жилүүдэд монголчуудын соёл иргэншил, уламжлалт үнэт зүйлд өөрчлөлт орж, шинэ шашны хөдөлгөөнүүд дэлгэрч, хүүхэд залуусын оюун санаанд өөрчлөлт орж байгааг холбогдох судалгааны тайланд²⁶ дурджээ. Тус судалгааны тайланд манай улсад шинээр орж ирж үйл ажиллагаа эрхэлж буй шашны хөдөлгөөнүүдийн талаар судалж, уламжлалт бус шинэ шашны итгэгчдийн тооноос гадна шинэ шашин шүтэгчид уламжлал, зан заншлын чиг баримжаа өөрчлөгдсөн талаар дүгнэсэн нь анхаарал татаж байна.

Иймээс холбогдох хууль тогтоомжоор соёл иргэншлийн аюулгүй байдалд хамаарах шашны асуудал хэрхэн туссан талаар тодруулах нь зүйтэй.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг үндэсний аюулгүй байдал гэж хуульчилж өгсөн. Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, *соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл*, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал нь үндэсний язгуур ашиг сонирхол. *Үндсэн хуулиар шашны асуудал Улсын бүрэн эрхт байдалд хамаарах, бурханы шашинд тусгай статус олгосон, “Шашин” бол үндэсний эв нэгдэл, соёл иргэншлийн*

оршин тогтнох үндэс суурь гэдгийг дээр дурдсан билээ.

Энэ утгаараа Монголын ард түмний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нийтийн язгуур ашиг сонирхолын хүрээнд монголчуудын соёл иргэншлийн аюулгүй байдлыг хамгаалан, хадгалан авч үлдэх нь төрөөс шашны талаар баримтлах бодлогын үндсэн зарчим мөн. Төр болон сүм хийдийн харилцаа, шашин хоорондын харилцаа, шашин шүтэх хувь хүний эрх чөлөөний ойлголт ч нийтийн эрх ашиг, үндэсний аюулгүй байдалтай холбогдож байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Үндсэн хуулийн шашны талаар баримтлах үзэл санааг хамгаалах, үндэсний аюулгүй байдлын талаархи төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс юм. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д оршин тогтнох аюулгүй байдлыг хангахын тулд уламжлалт Бурханы шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлэхээр тусгасан байна.

Мөн тус үзэл баримтлалаар иргэдийг үндэс угсаа, шашин шүтлэг,

26 Шинжлэх ухааны Академийн Философийн Хүрээлэн “Шинэ шашны сүсэгтнүүдийн Социологийн судалгааны тайлан 2017-2019” УБ., 2020. Тал 34. Доктор /Ph.D/, профессор С.Цэдэндамба, Доктор /Ph.D/ Ж.Алтайбаатар, Докторант С.Дэмбэрэл, Б.Мөнхцацрал “...Христийн шашнаас гаралтай шинэ шашны сүсэгтнүүдийн дотор үнэт зүйл, үнэлэмжийн хувьд жирийн Монгол хүнийхээс өөр чиг баримжаатай болж эхлэх үндэс тавигдсан гэж үзэж болохоор байна... Уламжлал, зан заншил, соёлд сөрөг байр суурийг баримтлах хандлагатай байгаа нь иргэдийн дотор соёлын зөрчил үүсэх эрсдэл бий болгож байна”

үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нутгархах үзлийг дэврээх, энэ шалтгаанаар хүний эрх, эрх чөлөөг зөрчих, улмаар үндэсний эв нэгдлийг сарниулж, дотоодын тогтворгүй байдалд хүргэж болох илрэлтэй хатуу тэмцэл²⁷ хийхээр тусгасан байна.

ҮАБ-ын Үзэл баримтлалд Монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурханы шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжих бөгөөд Монголын түүх, соёл, шашин, зан заншлыг хамгаалан хөгжүүлнэ гэж явцуу хүрээнд бодит байдал дээр хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй²⁸ байдлаар тусгаж өгсөн. Тодруулбал, соёл иргэншлийн аюулгүй байдалд уламжлалт бурханы шашныг нэр заан оруулсан мөртлөө тунхаг төдий тусгаж, тухайн шашныг хэрхэх нь тодорхойгүй, соёл иргэншлийг хамрах хүрээнд оруулсан ч зөвхөн өв соёлын судалгааг дэмжинэ гэсэн тодорхойгүй, бурханы шашны байр суурийг хамгаална гэсэн утга агуулаагүй, хатуу аргаар тэмцэнэ гэсэн нь хүний эрхийн зөрчил агуулсан, юуг, яаж хийх нь ойлгомжгүйгээр үзэл баримтлалд тусгасан байна.

Улмаар төрөөс шашны талаар баримтлах бодлогыг буруугаар тайлбарлаж, бусад шашин шүтлэгүүд шашин шүтэх хүний эрх чөлөөний

нэрийн доор манай улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй нэвтрэх болсон. Ийнхүү үйл ажиллагаа эрхлэх, шашны үзэл суртлаа түгээн дэлгэрүүлэхдээ хууль тогтоомжийн хүрээнд ямар нэгэн хязгаарлалт байхгүй мэтээр тайлбарлаж ирсэн байна. Үүний үр дагаварт Монгол Улс олон шашны үүр уурхай, шашны гаж урсгалуудын үзэл номлолоо түгээх орчин, барууны бусад соёл дэлгэрсэн, уламжлалт үнэт зүйлийг үгүйсгэсэн, шашны замбараагүй байдалтай болсон нь оршин тогтнохуйн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, соёл иргэншлийн аюулгүй байдалд ноцтой хор уршиг учруулж байна.

Төрөөс “*Шашин-сүм хийдийн талаархи төрийн бодлогын үзэл баримтлалыг*”-ыг²⁹ 1998 онд батлан гаргасан байх тул түүний хэрэгжилтэд дүгнэлт өгөх цаг болсон. Төрөөс шашны асуудлыг эмзэг сэдэв гэж үзэн, далд аргаар, бөөрөнхий байдлаар хандах нь явцгүй болохыг өнгөрсөн гучин жил бидэнд харууллаа. Учир нь Үндсэн хуулийн үзэл санааг буруу тайлбарласан, төрийн байгууллага зөвхөн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах үндсэн зарчимтай, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нөхцөлд зөвхөн үзэл баримтлал, зөвлөмж төдийгөөр тухайн ажлыг гүйцэтгэх боломжгүй гэдэг нь

27 Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, 3.3.3.4 дэх хэсэг <https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>

28 Үндэстний соёл иргэншлийн уг гарвал, мөн чанар нь шашин шүтлэг байдаг бол Аюулгүй байдлын үзэл баримтлалд монголчуудын уламжлалт итгэл үнэмшил, шашин шүтлэгийг хамгаалж дэмжсэн заалт өөр байдлаар тусгагдаагүй. Соёл судлал, аюулгүй байдлын судлаач эрдэмтэд соёлын талаас ихэвчлэн судалгаа шинжилгээндээ явцуу тайлбарлан дурдсанаас, шашин шүтлэгийн талаас нарийвчлан судалсан судалгаа байхгүй байна. Мөн үүнд дурдах ёстой нэг асуудал бол Бурахны шашны сүм хийд, бурхан тахил, эд хөрөнгийг төрийн өмч мэт ойлгодог буруу ойлголт сүүлийн үед газар авч байна. Энэ талаар судлаач өмчийн эрх зүйн онолын хүрээнд нийтлэл бичих болно.

29 Нацагийн Багабанди. “Шинэ цаг үе ба Монголын бурханы шашны өмнөх шинэ зорилт” УБ., 2001 он, тал 5

улам тодорхой болж байна.

Сүүлийн 30 жил “Шашны эрх чөлөө”³⁰, “шашин шүтэх эрх чөлөө”, хувь хүний итгэл үнэмшил, төрөөс шашны талаар баримтлах бодлого зэрэг ойлголтуудыг хэн дуртай нь өөрт ашигтайгаар тайлбарлаж ирсэн, нийгэмд ийм байр суурь, үзэл бодол газар авч улам дэлгэрсэн байна.

Үндэстнээрээ нэг зүгрүү харж, нэг итгэл үнэмшилтэй байна гэдэг аюулгүй байдлыг хангах суурь нөхцөл болж өгөх ба эс чадвал тэр үндэстэнд талцал хуваагдал, үл ойлголцол, үл хүндэтгэл зэрэг аюул занал, эрсдэл шууд учрах нөхцөл болж өгдөг. Үндэстний ухамсар, оюун санаа итгэл үнэмшлийн нэгдмэл байдал бол маш чухал ухагдахуун атал төрөөс үүнд огт анхаарсангүй. Анхаарах битгий хэл уламжлан ирсэн үндэстний соёл уламжлалыг илэрхийлсэн төрийн хүндэтгэлийн ажиллагааг цуцалсан. Тодруулбал төрийн тэргүүн нь жил бүр цагаан сарын их баяраар монгол түмний их шүтээн Жанрайсиг бурханд хүндэтгэл үзүүлдэг уламжлагдан ирсэн хүндэтгэлийн ажиллагааг сүүлийн жилүүдэд огт хийсэнгүй. Төрийн тэргүүн нь Гандантэгчинлэн хийдэд зочлох нь төр, ард түмний уламжлалт соёлыг хүндэтгэдэг хүндлэл, төрийн их ёслол болохоос төрийн зүгээс шашны хэрэгт оролцсон, төр шашны өмнө бөхийсэн үйлдэл биш юм.

Олон шашны үзэл номлол нэг үндэстэнд дэлгэрч айл гэр, хувь хүн бүр өөр өөр шашинд итгэж үнэмших нь юмсыг таньж мэдэх, ертөнцийг үзэх үзлээр ялгарч нийгмийн үл ойлголцол, талцал хуваагдлын шалтгаан болно. Нэг үндэстэн шашнаар биенээ үгүйсгэх, үзэл бодлоор нэгнээ ялгаварлан гадуурхах зэрэг бусармаг үйлдэл гарахгүй гэх газар үгүй бөгөөд, түүнийг бий болгох үндэс суурийг одооноос эхлэн нэн даруй таслан зогсоох ёстой.

Монгол Улсын шашны нөхцөл байдлын түвшин

2019 онд ШУА-ийн Философийн хүрээлэнгээс хийсэн “Шинэ шашны хөдөлгөөний социологийн судалгаа”-нд шинэ шашны хөдөлгөөний 49 урсгал³¹ манай улсад үйл ажиллагаа эрхэлж, шинэ шашны сүсэгтнүүдийн дотор залуучуудын эзлэх хувь хэмжээ өндөр байна. Шинэ шашны сүсэгтнүүдийн 54.5% хувь нь 30 хүтэлх насныхан байгаа нь залуу үеийнхнийг өөрийн эгнээндээ нэгтгэдэг шинэ шашин, шинэ шашны хөдөлгөөний нэг чухал онцлог болж байна³² гэж дүгнэжээ.

Монгол Улсын хэмжээнд 3 сая гаран хүн амд 50 гаран шашны урсгал гаднаас орж ирж, шашны номлол сургаалиа дэлгэрүүлж, улсын хэмжээнд

30 Зохиогчийн “Шашны эрх чөлөө юу, Шашин шүтэх эрх чөлөө юу” өгүүллийг доорх сайтаас үзнэ үү.
<http://legaldata.mn/b/210>

Тус нийтлэлээр “Шашны эрх чөлөө” ба “Шашин шүтэх эрх чөлөөний” зааг ялгааг онцолж, тэдгээрийн шинж чанар, адил төстэй талыг хэм хэмжээний хувьд тодорхойлсон.

31 Шинжлэх ухааны Акедимийн Философийн Хүрээлэн, Доктор /Ph.D/, профессор С.Цэдэндамба, Доктор / Ph.D/ Ж.Алтайбаатар, Докторант С.Дэмбэрэл, Б.Мөнхцацрал “Шинэ шашны сүсэгтнүүдийн Социологийн судалгааны тайлан 2017-2019” УБ., 2020. Тал 34.

32 Мөн тэнд, Тал 34.

800 гаран шашны байгууллага,³³ цуглаан ажиллаж байгаа, гаднаас зохион байгуулалттай зөөвөрлөгдөн орж ирсэн шашин нь ихэвчлэн залуус хойч үед анхаарч ажилладаг зэргээс үзвэл дээр дурдсан Монгол Улсын соёл иргэншлийн аюулгүй байдалд шууд эрсдэлтэй гэж үзэж болохоос гадна хэт замбараагүй, үзэл бодол, итгэл үнэмшлийн тухайд зөрчилдөөн бий болох хөрс суурь тавигдсан гэж дүгнэж болно.

Зарим судлаач энэхүү нөхцөл байдал бол хүний эрхийг хэрхэн хангаж байгаа сайн үзүүлэлт хэмээн дүгнэх, иргэд итгэл үнэмшлээр зөрчилдөхгүй шашны эрх чөлөө хангагдсан зэргээр хөөргөх, тайлбарлах явдал Монголын нөхцөл байдалд тохирохгүй юм гэдгийг дээр өгүүлсэн нөхцөл байдал илэрхийлж байна.

Гаднаас орж ирж байгаа зохион байгуулалттай шашин, сүсэгтнүүдийн итгэл үнэмшил нийгмийг талцал хуваагдалд хүргэх, эрсдэлд оруулах, нийгмийн аюулгүй байдалд нөлөөлөхөөс гадна Шашны хэт үзэлтэй³⁴ хүмүүс аюулгүй байдалд нөлөөлөх, гадаад улсаас ямар нэгэн зорилгоор шашныг зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх, халхавч байгууллагаар мөнгө угаах, ашиг олох³⁵, улмаар үндэстний ухамсар, үндэсний соёл иргэншлийг үгүйсгэх,

өөрчлөх хандлага, газар авахыг үгүйсгэхгүй.

Шашин сүм хийдийн тухайд төрөөс баримтлах бодлогын судалгааны тайлан, шашны талаар авч хэрэгжүүлэх бодлогын судалгаанд “*шашны байгууллагууд халхавч байгууллагын хүрээнд, хүмүүнлэгийн байгууллагын нэрээр болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаар, нууц, зөвхөн гишүүддээ үйлчилдэг монголчуудад хаалттай үйл ажиллагаа эрхэлдэг, мөн нийгмийн тодорхой салбарыг сүсэгтний хувь хэмжээгээр эзэлж авах, эрх мэдлээ тогтоох гэсэн хүсэл эрмэлзэл шашны байгууллагад илрэх болсон*” талаар дурдсан³⁶ байна.

Энэхүү байдлаас харахад өнгөрсөн хугацаанд гаднаас шашныг зохион байгуулалттайгаар нэвтрүүлсэн, шашны номлол сургаалиа нийслэл, орон нутагт хүмүүнлэгийн болон төрийн бус байгууллагын нэр доор явуулж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, монголчуудыг Христийн дагалдагч болгож, бүх үндэстэнд түүний хаанчлалын сайн мэдээг түгээх, улмаар төрийн эрх мэдэлд өөрсдийн итгэл үнэмшилтэй хүмүүсийг оруулахад чиглэн ажиллаж төрийн эрх мэдлийн төлөө ажилладаг зүйл ажиглагдаж байна.

33 Хууль зүйн яамны 2015 оны “Шашны байгууллагуудад хийсэн судалгаа”-ны тайлан

34 Шашны хэт итгэл үнэмшилтэй хүмүүс нь шашны үзэл номлолынхоо үүднээс асуудлыг тайлбарлах, хандах, нийгмийг талцал хуваагдалд уриалах зэрэг эрсдэлтэй бөгөөд сүүлийн үед цахим орчинд ялгаварлан гадуурхах, биенээ үгүйсгэх энэ төрлийн үзэгдэл түгээмэл болсон.

35 Шашны байгууллагын үйл ажиллагааг хүмүүс итгэл үнэмшил дээр тулгуурлан явуулдаг боловч зарим талаар шашны байгууллагын санхүүжилт нь зохион байгуулагчид ашиг олох шинж чанартай байна. Гаднаас шашны байгууллагын нэр дээр хөрөнгө босгон, тэдгээрийн санхүүжилтээр манай улсад үйл ажиллагаагаа явуулахдаа үл хөдлөх хөрөнгө, компани байгуулсан нь тогтоогдсон байдаг.

36 Үндэсний хөгжлийн хүрээлэн. Ж.Алтайбаатар “Шашин сүм хийдийн тухайд төрөөс баримтлах бодлого, зохицуулалтын тулгандсан асуудал, шийдвэрлэх арга зам” УБ., 2015.

Санал, дүгнэлт

Шашны харилцаа нь Монгол Улсын “Бүрэн эрхт байдал”, Үндэсний аюулгүй байдлын оршин тогтнохуйн дотоод аюулгүй байдал буюу соёл иргэншлийн аюулгүй байдалд хамаарах асуудал байна.

Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 9 дүгээр зүйлээр Улсын бүрэн эрхт байдалд хамаарах төрөөс шашны талаар баримтлах бодлогыг тодорхой тусгаж зохицуулсан бол Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд Хүний эрх, эрх чөлөө болох шашин шүтэх хүний эрх, эрх чөлөөг тусгайлан хуульчилж өгсөн байна. Үндсэн хуулийн тухайн зүйл, заалтууд нь хэдийгээр харилцан хамааралтай боловч зохицуулалт нь бие даасан өөр, өөр зорилго агуулгыг илэрхийлсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаагаар Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин төрөө дээдэлнэ” гэсэн нь уламжлалт бурханы шашинд тусгай статус олгосон, төрийн зүгээс уламжлалт бурхан шашинд хүндэтгэлтэй хандах агуулгатай тул энэхүү үзэл баримтлалыг нийгэмд тодорхой тайлбарлан таниулах шаардлагатай байна. Үндсэн хуульд заасан төрөөс шашны талаар авч хэрэгжүүлэх бодлогын хүрээнд соёл иргэншлийг хамгаалах, уламжлалт бурханы шашны байр суурийг хүндэтгэн үзэх, нийгмийн аюулгүй байдалд анхаарч, холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулах шаардлагатай байна. Энэхүү баримт бичгийг Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд, агуулгын хувьд

хууль дээдлэх зарчмыг үндэслэн боловсруулах нь зүйтэй юм.

Манай улсын хүн амтай харьцуулахад хэт олон шашны урсгал гадаадаас орж ирсэн замбараагүй байдал бүхий нөхцөл байдлаас харвал соёл иргэншлийн аюулгүй байдалд аюул занал учруулсан, цаашид ард иргэд, үзэл бодол, итгэл үнэмшлээр талцан хуваагдах зэрэг нийгэмд сөрөг үзэгдлүүд гарч болзошгүй юм. Иймд бодит байдлыг судлан үзэж, соёл иргэншлийн аюулгүй байдалд хамаарах шашны асуудалд одооноос анхаарч, гарч болзошгүй аливаа эрсдэлээс төрийн зүгээс цаг алдалгүй урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй байна.

Монгол улс нь бусад улс орнуудаас соёл иргэншил, нийгмийн ухамсар, уламжлал, үнэт зүйл зэрэг өөрийн онцлогтой учраас шашны талаар төрөөс баримтлах бодлогыг бусад улсуудаас шууд хуулбарлан буулгах боломжгүй гэдгийг анхаарч үзэн эрх зүйн зохицуулалт, эрх зүйн соёлын онцлогт таарсан бодлогыг баримтлах ёстой.

Гадаад улс орнуудаас шашнаар дамжуулан Монгол улсын соёл иргэншлийн аюулгүй байдалд ноцтойгоор аюул занал учруулж байж болзошгүйг төрийн эрх бүхий байгууллага анхааралдаа авч Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах цаг болсон байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. 1993 он
- БНМАУ-ын АИХ-ын 2 дахь удаагийн сонгуулийн II хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл. 1991.11.25. /соронзон хальсны бичлэг кассет Y-54/
- Үндсэн хуулийн цэцийн 1994.01.12-ны өдрийн хуралдааны ТСХХтХуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн маргааныг хянан хэлэлцсэн хурлын тэмдэглэл.
- Д.Гангабаатар “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө ба Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн проктик” Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2017. дугаар 02, цуврал 62
- Law on freedom of conscience and religious associations “The Federal Assembly of the Russian Federation, recognizing a special role of the Orthodox Church in the history of Russia, the formation and development of its spirituality and culture, “ /орч/
- Бүгд Найрамдах Польш Улсын “Үндсэн хууль” орч. Б.Лхагважав, Ж.Алтангэрэл
- Бүгд Найрамдах Итали Улсын “Үндсэн хууль” орч. Ж.Амарсанаа
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын “Үндсэн хууль” орч. П.Амаржаргал Х.Ариунсүрэн нар. УБ., 2020.
- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хувийн хэрэг. УИХ-ын тамгын газар.
- Самуэл П.Хатингтон “Иргэншил хоорондын мөргөлдөөн ба Шинэчлэгдсэн дэлхийн дэг журам” УБ., 2018. Орч. А.Энхбаатар
- ШУА-ийн Философийн Хүрээлэн “Шинэ шашны сүсэгтнүүдийн Социологийн судалгааны тайлан 2017-2019” УБ., 2020. Тал 34. Доктор /Ph.D/, профессор С.Цэдэндамба, Доктор /Ph.D/ Ж.Алтайбаатар, Докторант С.Дэмбэрэл, Б.Мөнхцацрал
- Н.Багабанди. “Шинэ цаг үе ба Монголын бурханы шашны өмнөх шинэ зорилт” Улаанбаатар, 2001.
- Хууль зүйн яамны 2015 оны “Шашны байгууллагуудад хийсэн судалгаа”-ны тайлан
- Үндэсний хөгжлийн хүрээлэн. Ж.Алтайбаатар “Шашин сүм хийдийн тухайд төрөөс баримтлах бодлого, зохицуулалтын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” УБ., 2015.
- “Civilization is the ultimate destiny of Culture” Assem Koishybayeva “Essay The Decline of the West by Oswald Spengler” p.,2 https://www.academia.edu/10710737/Essay_The_Decline_of_the_West_By_Oswald_Spengler

- Mubarak Ali “Toynbee on civilisation” <https://www.thenews.com.pk/print/325178-toynbee-on-civilisation>
- Amartya Sen “Democracy as a Universal value”., Journal of democracy, №3-17, 1999 https://www.unicef.org/socialpolicy/files/Democracy_as_a_Universal_Value.pdf p.,9
- Paul Berman “Terror and liberalism”., 2003, Norton&company <https://www.commentarymagazine.com/articles/david-warren/terror-and-liberalism-by-paul-berman-the-crisis-of-islam-by-bernard-lewis/>
- М.Амарбаяр “Шашны эрх чөлөө юу, Шашин шүтэх эрх чөлөө юу” <http://legaldata.mn/b/210>

Some issues related to concept of the Constitution and security of civilization

Amarbayar Myagmarsuren

Lawyer, Researcher /LL.M/

E-mail: amarbayar04@gmail.com

Abstracts: *The state of affairs concerning religion in Mongolia has recently become a controversial subject due to the need to clarify the constitutional and state policy on religion, which was being interpreted in different ways by scholars. I the researcher concluded my thoughts on how the constitution of Mongolia stipulated “religion”, whether the main principle such as “The State shall respect religion and religion shall honor the State” is referring to all religions, and clarified the constitutional concept of state and religion in the constitution. Religion is not merely a matter of religious human right, it is also essential matter in terms of national security and national integration. Furthermore, I the researcher tried to define the scope of religion in broad concept of “Civilization” and how it is regulated by the law of national security.*

Keywords: *The Constitution, Concept of the Constitution, State policy on religion, National security, Civilization, Role of state.*

<i>The day of submission:</i>	<i>2020.4.30</i>
<i>Completion of review:</i>	<i>2020.6.18</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2020.6.20</i>